

АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

I. ӨРХ, ХҮН АМ: Оны эцэст 15.8 мянган өрх, 55.1 мянган суурин хүн амтай болж, урьд оноос өрхийн тоо 281-ээр, хүн амын тоо 276-аар өслөө. Нийт өрхийн 49.3 хувь буюу хүн амын 51.2 хувь нь хөдөөд амьдарч байна. Нийт өрхийн 27.6 хувь нь байшинд амьдарч байгаа бөгөөд урьд оноос 1.3 пунктээр өслөө. Төвлөрсөн халаалттай орон сууцанд 1185 өрх өмьдөрч байгаа нь урьд оноос 165 өрхөөр өссөн байна. 96.1 хувь нь хувийн өмчийн сууцанд амьдарч байна.

Хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт хүн амын 66.7 хувийг 15-59 насныхан, 28 хувийг 0-14 насныхан, 5.3 хувийг 60 ба дээш насныхан эзлэх болсноор хүн ам зүйн ачаалал 49.9 хувьтай болж, хөдөлмөрийн насны 2 хүнд 1 тэжээлгэгч хүн ногдож байна.

66 багаас хамгийн олон том баг нь Баруун-Урт сумын 5-р баг 869 өрх, 2832 хүнтэй байхад хамгийн жижиг баг нь Халзан сумын 2-р баг 69 өрх, 255 хүнтэй байна.

2011 онд 530 хүн шилжин ирж, 1168 хүн гадагш шилжин явсан нь урьд оноос 105-252 хүнээр тус тус буурсан байна. Шилжин явагсдын 57.8 хувь нь Улаанбаатар хот руу шилжсэн байна.

II. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 9.8 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 30.9 хувиар давж биелсэн нь өмнөх оныхоос 2.4 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

Бүх сум төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, дүнгээр 9.5 хувиар буюу 222.5 сая төгрөгөөр давууллаа.

Орон нутгийн төсвийн зарлага 8.5 тэрбум төгрөг болжээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 4.4 тэрбум төгрөгт хүрсний дотор нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээний салбарт 2 тэрбум төгрөг, барилгын салбарт 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь хамгийн их нь байна.

III. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр Арилжааны банкуудын ААНБ, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 35.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 15.5 тэрбум төгрөгөөр буюу 79.4 хувиар өсчээ.

Иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 16.8 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 5.4 тэрбум төгрөгөөр буюу 47.1 хувиар өссөн байна.

IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Малтай болон малчин өрх, малчид: Аймгийн нийт өрхийн 57.9 хувь болох 9.1 мянган өрх аминдаа 2054.6 мянган мал тоолуулсан нь нийт малын 98.7 хувийг эзэлж байна. Малчин өрх 6834, малчдын тоо 14921 болсны дотор 16-34 насны залуу малчдын хувийн жин буурч, 47.3 хувьд хүрлээ.

Нийт малтай өрхийн 61.8 хувийг 200 хүртэл малтай өрх эзлэх болж жил дараалан буурч, харин 200-аас дээш малтай өрхийн тоо жил дараалан өсч, чанарын өөрчлөлт гарч байна. 226 өрх мянгаас дээш мал тоолуулж, шинээр 50 мянгат малчин төрлөө.

Мал аж ахуй: Мал сүрэг урьд оноос 101.6 мянган толгойгоор өсч, 2.1 сая мал тоологдсоны дотор тэмээ 10.7 мянга, адуу 164.9 мянга, үхэр 136.6 мянга, хонь 992.0 мянга, ямаа 777.2 мянга болж, тэмээнээс бусад 4 төрөл дээрээ өслөө.

Асгат, Эрдэнэцагаан, Наран сумдаас бусад бүх сумд малаа өсгөсний дотор Дарьганга, Мөнххаан, Онгон, Түвшинширээ, Уулбаян, Баруун-Урт сумд 5 төрөл дээр нь малаа өсгөсөн байна. Нийт сумдын 23.1 хувь нь 200.0 мянгаас дээш мал тоолуулсны дотор Баяндэлгэр сум 271.8 мянган малаар аймагтаа тэргүүлж байна.

Малын тоог багаар авч үзвэл: 66 багийн 19 нь 40.0 мянгаас дээш малтай байгаагийн дотор хамгийн олон малтай нь Баруун-Урт сумын 8-р баг 75.6 мянган малаар тэргүүлж байна.

Нийт 903.6 мянган хээлтэгч тоологдсон нь нийт малын 43.4 хувийг эзэлж байна.

Оны эхний эх малын 87.4 хувь буюу 750.2 мянган эх мал төллөж, гарсан төлийн 98.3 хувь буюу 744.7 мянган төл бойжуулж авлаа.

Оны эхний малын 2.8 хувь болох 54.6 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оноос 0.6 пункт буюу 6.3 мянгаар доогуур байна.

Газар тариалан: Энэ онд төмс 67.1 га-д, хүнсний ногоо 30.24 га-д тариалж, 647.5 тн төмс, 212.1 тн хүнсний ногоо тус тус хураан авсан нь урьд оноос төмс 48.0 хувиар дээгүүр, хүнсний ногоо 2.4 хувиар доогуур байна.

Хадлан 11.0 мянган тн, гар тэжээл 729.2 тн, тэжээлийн ургамал 53.6 тн-ыг бэлтгэсэн байна.

V. БЕЗНИС РЕГИСТРИЙН САН: Бизнес регистрийн санд 521 ААНБ бүртгэлтэй байгаа бөгөөд 491 буюу 94.2 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Бүртгэлтэй ААНБ-ын тоо урьд оноос 58-аар, үйл ажиллагаа явуулж байгаа ААНБайгууллага 70-аар нэмэгдсэн байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл: ХХК 46.1 хувь, төрийн байгууллага 22.3 хувь, ЗБН 7.3 хувь, ТББ 12.1 хувь, ББН 5.6 хувь, Хоршоо 4.4 хувийг тус тус эзэлж байна. Өмчийн хэлбэрээр нь авч үзвэл: Хувийн хэвшил 75.2 хувийг эзэлж байна.

ААНБ-ын тооллогоор 543 ААНБ тоологдсны дотор ААНэгж , төрийн байгууллага, төрийн бус байгууллага тус тус тоологдсон байна.

VI. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 28.4 тэрбум төгрөг болсон нь өмнөх оноос 0.3 тэрбум төгрөг буюу 1 хувиар доогуур байна.

Аж үйлдвэрийн нийт борлуулалт 99.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 5.3 тэрбум төгрөгөөр буюу 5.1 хувиар доогуур гүйцэтгэлтэй байна.

Энэхүү бууралтад цайрын баяжмалын үнэ, агууламж буурсантай холбоотойгоор үйлдвэрлэлт, борлуулалт буурсан.

Гол нэр төрлөөс талх, хиам, нүүрс, эсгий, блок, тоосго, замын хавтан, боржуур, дулаан үйлдвэрлэлт 16.2-585.9 хувиар өсч, шинээр зарим хүнсний бүтээгдэхүүн, төмөр болон модон эдлэл, оёдлын нэр төрөл нэмэгдсэн байна.

VII. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Нийт 7.6 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь урьд оноос 34.8 хувиар өссөн байна. Шинээр 14 барилга,байгууламжийг ашиглалтанд оруулсан байна.

Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 187.6 мян.тн ачаа, давхардсан тоогоор 25.1 мян. хүн тээвэрлэж, ачаа эргэлт 45.9 сая.тн км, зорчигч эргэлт 12.1 сая хүн км-т хүрсэн байна Тээсэн ачаа өнгөрсөн оноос 12.3 мян.тн буюу 7.0 хувь,зорчигчдын тоо 2.3 мян зорчигч буюу 10.1 хувиар тус тус өсчээ. 5.3 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос 4.2 хувиар өссөн байна.

Авто тээврийн хэрэгслийн тооллогын дүнгээр 6436 тээврийн хэрэгсэл тоологдсон нь урьд оноос 53.5 хувиар өссөн байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл: авто машин 60.9 хувь буюу 3.9 мянга нь, мотоцикль 33.5 хувь буюу 2.4 мянга нь, чиргүүл 2.0 хувь буюу 0.1 мянга нь, механизм 0.5 хувь буюу 0.5 мянга нь байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 339.9 сая төгрөг болсны дотор хүн амаас 166.7 сая төгрөг орсон нь урьд оноос нийт орлого нь 4.9 хувиар , хүн амаас орох орлого 6.4 хувиар тус тус өссөн байна.

VIII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 9.3 хувиар өссөнд холбоо, эм, тариа эмнэлэгийн үйлчилгээнээс бусад бүх бүлгийн барааны үнэ тариф 0.1-23.7 хувь өссөн нь нөлөөлжээ

IX. БОЛОВСРОЛ,СОЁЛ: 2011-2012 оны хичээлийн жилд 368 бүлэгт 10.3 мянган хүүхэд суралцаж байгаагийн 50.0 хувь нь эмэгтэй сурагчид байна.

1-р ангид 882 хүүхэд элсэн орж, бага ангид 5.3 мянга, дунд ангид 3.6 мянга, ахлах ангид 1.4 мянган хүүхэд суралцаж байна.

Энэ жил 15 сургуульд 891 хүн ажиллаж байгаагийн 678 буюу 76.1 хувь нь эмэгтэй багш байна.

ЕБС-ийн нийт ажиллагсадын дотор үндсэн багшийн эзлэх хувь аймгийн дүнгээр 58.5 хувьтай байгаагийн дотор Бүрэнцогт, Тэмүүлэл, 1-р 10 жил, Эрдэнэцагаан сумдад 80.0-59.3 хувь нь үндсэн багш нар байна.

Соёл: Хөгжимт жүжгийн театр 2011 онд 22.9 мянган үзэгчдэд 17 тоглолтоор үйлчилж 16.0 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Музей: 1.8 мянган үзмэрээр 3.5 мянган хүнд үйлчилж, 749.0 мянган төгрөгийн орлого олжээ.

Нийтийн номын сан: 26.9 мянган уншигчдад 42.8 мянган номоор үйлчилж 1026.7 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

X. ЭРҮҮЛ МЭНД: 1288 эх амаржиж, 1297 хүүхэд төрсөн бөгөөд 1-5 хүртэлх насандаа 8 хүүхэд эндсэн нь урьд оноос 3-аар олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 652 болж, урьд оноос 61-ээр өссөний дотор сүрьеэ, тэмбүү, заг, трихоминиаз зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

XI. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 812 болж, өмнөх оныхоос 95-аар буурчээ. Ажилгүй иргэдийн 79.8 хувь нь 16-34 насны залуучууд, 38.9 хувь нь бүрэн дунд, 19.8 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. 3556 хүн шинээр бүртгүүлж, 3235 хүн ажилд орсны дотор 1188 нь шинэ ажлын байр байна.

XII. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ОРЛОГО: 3-р улирлын түүвэр судалгаанд хамрагдсан 40 ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин, орлогыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилалаар авч үзэхэд: Санхүү, уул уурхай, цахилгаан эрчим хүчний салбар өндөр үзүүлэлттэй байна.

XIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 5.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Сайн дурын даатгалын шимтгэлийн орлогод 153.8 сая төгрөг орж, төлөвлөгөө 37.8 хувиар давж биелсэн.

6017 өндөр настанд 7.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 1.4 тэрбум төгрөгийг 5.2 мянган иргэнд, улсын төсвөөс 16.1 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 59.7мянган иргэнд тус тус олгосны дотор хүний хөгжил сангаас 14.9 тэрбум төгрөгийг 54.1 мянган иргэнд олгосон байна.

XIV. ГЭМТ ХЭРЭГ: Энэ онд 238 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оноос 38 хэрэг буюу 19 хувиар өссөн байна. Гэмт хэргийн улмаас 46 хүн нас барж, 71 хүн гэмтсэн нь урьд оноос өссөн байна. ААНБ, иргэдэд 128.1 сая төгрөгийн хохирол учирсны 123.5 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 228 хүн сэжиглэгдсэний 17.1 хувь нь бүлэглэнгээр, 28.1 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 2978 эрүүлжигдсэн нь урьд оноос 306 хүнээр өсчээ.

XV. ТӨСӨЛ: **Малын индексжүүлсэн даатгал төсөл** 13 суманд хэрэгжиж 854 өрхийг хамруулж 64.5 сая төгрөгийн хураамж авсан нь урьд оноос өрхийн тоо 31.6 хувь, хураамж 25.0 хувиар өссөн байна.

2010 онд МИД төсөлд хамрагдсан сумдаас Асгат, Дарьганга, Наран, Эрдэнэцагаан сумдын 158 өрхөд 10.2 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөлд хамрагдахаар 1.4 тэрбум төгрөгийн 45 төслийг иргэд ирүүлснээс шат шатны шалгуураар орж, 960.0 сая төгрөгний 25 төсөл батлагдаж санхүүжилтээ авсан нь урьд онтой зэрэгцүүлэхэд төслийн тоо 46 хувиар буурч, санхүүжилт нь 60 хувиар өссөн нь 5 сумын цөөн том төслүүдэд зээлийг олгожээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 144 иргэнд 237.2 сая төгрөгийн зээл олгож, 244 ажлын байр бий болгосны дотор Сүхбаатар сумын 34 иргэн 31.5 сая, Уулбаян сумын 27 иргэн 29.5 сая, Эрдэнэцагаан сумын 29 иргэн 29.1 сая төгрөгийн зээл авч ажлын байртай болсон нь бусад сумдаас дээгүүр байна.

2010 онд уг сангаас 389.2 сая төгрөгийн зээлийг иргэдэд олгож байсан байна.

Тогтвортой амьжиргаа-II төслөөр 189.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдснээс тохижуулалтанд 22 сая, засварт 27.5 сая, шинээр 13.8 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

XVI. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Аймгийн хэмжээнд нийт өссөн дүнгээр 6015 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 5851 иргэнд 553.13 га газар өмчлүүлэх шийдвэр гарсан байна.

Үүнээс: 2011 онд 837 иргэн өргөдөл гаргаж, 904 иргэнд 75.95 га газрыг өмчлүүлэх шийдвэр гарчээ.

Нийт 2755 иргэн газрын гэрчилгээгээ авч баталгаажуулсны дотор 2011 онд 325 иргэн газар өмчлөлийн гэрчилгээгээ авсан байна.

XVII. ДААТГАЛ: Даатгалын кампаниуд 37.4 мянган иргэнийг 14 төрлийн даатгалд хамруулан 175.7 сая төгрөгийн хураамжийн орлого оруулснаас 569 иргэнд 25.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна. Хураамжийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 55.6 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.



Статистикийн хэлтсийн дарга  О.Цэрэндулам.